



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/455

Мандалговь

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 34 дугаар зүйлийн 34.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх Цагаандэлгэр сумын "Халуун ус, ахуйн үйлчилгээний төвийн барилга"-ын ажлын гүйцэтгэгчээр "Одда Тайж" ХХК-ийг сонгон 237,309,289 (хоёр зуун гучин долоон сая гурван зуун есөн мянга хоёр зуун наян ес) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг төсвийн дагуу "Халуун ус, ахуйн үйлчилгээний төвийн барилга"-ын ажлыг чанартай хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "Одда тайж" ХХК-ны захирал (Д.Ундармаа)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Цагаандэлгэр сумын засаг дарга (Д.Буджав) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010433